ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Дөрвөлжин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн хураангуй аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/031/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2026 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Алтан-Тосон аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: altantosonaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан 13
   4.1 Ерөнхий зүйл 13
   4.2 Материаллаг байдал 14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16
5. Аудитын илрүүлэлт 16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-3612
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.13 № 149

танай ________ -ны № ________ -т

ДӨРВӨЛЖИН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.АМАРЖАРГАЛ-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөрвөлжин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дөрвөлжин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дөрвөлжин сумын Ерөнхий боловсролын сургуульд Боловсролын яамнаас 26,500,000 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, сурах бичиг, биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох “Тахь” төслийн хүрээнд 24,294,200 төгрөгийн тоног төхөөрөмж, төсөгчдөөс 4,190,000 төгрөгийн зөөврийн компьютер, сум хөгжүүлэх сангаас 31,000,000 төгрөгийн дотуур байрын тавилга эд хогшил, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 2,500,000 төгрөгийн цахилгаан үүсгүүр нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Дөрвөлжин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан томилолтоор ажилласан албан хаагчдад 45,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон, сургуулийн захиралд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэмэгдэл хөлсөнд 2,483,563 төгрөгийн урамшуулал, захирлын

тушаалаар ёс зүйн дээд хорооны гишүүдэд 1,892,484 төгрөгийн урамшуулал, багш, ажилтнуудын ээлжийн амралт, цалинг давхардуулан 20,059,196 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Дөрвөлжин сумын Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Боловсролын газар болон Монгол Улсын Боловсролын Их сургуулиас 16 багшид цахим сургалтуудыг авч, 1,320,000 төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **326,549,048.11** | **162,593,828.71** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 272,743,244.75 | 90,393,344.79 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 272,743,244.75 | 90,393,344.79 |
| **3121** | **Төгрөг** | 272,743,244.75 | 90,393,344.79 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 272,743,244.75 | 90,393,344.79 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 16,896,198.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 16,896,198.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 16,896,198.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 53,805,803.36 | 55,304,285.92 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,822,222.00 | 7,354,800.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,822,222.00 | 7,354,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 44,983,581.36 | 47,949,485.92 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 920,558.00 | 803,708.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,641,620.00 | 13,412,900.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,770,000.00 | 4,898,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,550,317.22 | 1,816,241.82 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,101,086.14 | 27,018,636.10 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,320,778,736.78** | **1,331,827,301.30** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,320,778,736.78 | 1,331,827,301.30 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,281,604,736.78 | 1,285,747,301.30 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,167,222,389.00 | 1,167,222,389.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -142,566,547.32 | -165,420,062.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 23,000,000.00 | 23,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -23,000,000.00 | -23,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 329,793,542.07 | 308,904,904.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -126,527,828.76 | -135,340,758.54 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 60,383,290.00 | 115,681,236.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -28,892,408.53 | -26,724,707.51 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,683,200.00 | 1,683,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -692,000.00 | -1,460,000.00 |
| 39217 | Ном | 21,201,100.32 | 21,201,100.32 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 39,174,000.00 | 46,080,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,210,000.00 | 2,210,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,220,000.00 | -2,210,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 38,184,000.00 | 46,080,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,647,327,784.89** | **1,494,421,130.01** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **93,105,081.41** | **42,498,450.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 93,105,081.41 | 42,498,450.00 |
| **413** | **Өглөг** | 93,105,081.41 | 42,498,450.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 93,105,081.41 | 42,498,450.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 93,105,081.41 | 42,498,450.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,554,222,703.48** | **1,451,922,680.01** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,554,222,703.48 | 1,451,922,680.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 279,145,995.32 | 279,145,995.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 279,145,995.32 | 279,145,995.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 738,095,211.54 | 635,795,188.07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 738,095,211.54 | 738,095,211.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -102,300,023.47 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 536,981,496.62 | 536,981,496.62 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,647,327,784.89** | **1,494,421,130.01** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,478,586,847.60** | **1,415,077,043.52** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,680,347.60** | **100,118,743.52** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 60,680,347.60 | 100,118,743.52 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 60,680,347.60 | 86,060,743.52 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,044,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,600,000.00 | 3,600,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 56,036,347.60 | 82,460,743.52 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 14,058,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,417,906,500.00** | **1,314,958,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,273,728,800.00 | 1,167,596,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,273,728,800.00 | 1,167,596,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 144,177,700.00 | 147,361,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 144,177,700.00 | 147,361,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,231,814,496.02** | **1,517,377,066.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,231,814,496.02** | **1,517,377,066.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,197,030,638.39 | 1,469,591,542.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 830,359,557.00 | 1,028,612,703.00 |
| 210101 | Үндсэн цалин | 516,457,358.00 | 594,179,245.00 |
| 210102 | Нэмэгдэл | 277,890,959.00 | 351,520,858.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 30,600,000.00 |
| 210104 | Урамшуулал | 36,011,240.00 | 52,312,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 109,452,936.41 | 130,965,218.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,858,445.41 | 90,856,074.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,323,394.00 | 10,236,258.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,915,166.00 | 5,104,929.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,179,409.00 | 4,953,591.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,176,522.00 | 19,814,364.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 130,584,191.96 | 139,486,163.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,144,948.36 | 9,526,851.43 |
| 210302 | Түлш, халаалт | 120,879,043.60 | 127,400,912.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,560,200.00 | 2,558,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 8,734,235.56 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 8,734,235.56 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,307,776.79 | 34,795,485.40 |
| 210502 | Хоол, хүнс | 20,307,776.79 | 34,795,485.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,013,100.00 | 2,372,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,013,100.00 | 2,372,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,374,490.76 | 6,293,850.96 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,044,000.00 | 161,802.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,330,490.76 | 6,132,048.96 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 95,938,585.47 | 118,331,885.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,128,197.00 | 24,419,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,499,300.00 | 8,580,450.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 73,311,088.47 | 85,331,635.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 34,783,857.63 | 47,785,524.57 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,237,805.99 | 44,410,188.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,639,805.99 | 39,011,990.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,598,000.00 | 5,398,198.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,546,051.64 | 3,375,336.57 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **246,772,351.58** | **-102,300,023.47** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **246,772,351.58** | **-102,300,023.47** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,422,550,500.00** | **1,332,616,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,644,000.00** | **17,658,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,644,000.00 | 17,658,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,644,000.00 | 3,600,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,044,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,600,000.00 | 3,600,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 14,058,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,417,906,500.00** | **1,314,958,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,273,728,800.00 | 1,167,596,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,273,728,800.00 | 1,167,596,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 144,177,700.00 | 147,361,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 144,177,700.00 | 147,361,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,171,213,499.76** | **1,488,466,199.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,171,213,499.76** | **1,488,466,199.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,137,028,938.12** | **1,425,836,567.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 827,477,712.00 | 1,028,612,703.00 |
| 210101 | Үндсэн цалин | 515,840,212.00 | 582,051,594.00 |
| 210102 | Нэмэгдэл | 268,300,410.00 | 369,386,459.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 28,305,000.00 |
| 210104 | Урамшуулал | 43,337,090.00 | 48,869,650.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 112,229,400.00 | 131,070,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,316,000.00 | 89,128,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,978,300.00 | 10,485,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,489,200.00 | 5,242,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,489,200.00 | 5,242,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,956,700.00 | 20,971,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 137,631,648.36 | 139,486,163.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,144,948.36 | 9,526,851.43 |
| 210302 | Түлш, халаалт | 127,926,500.00 | 127,400,912.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,560,200.00 | 2,558,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 24,461,390.00 | 32,520,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,461,390.00 | 32,520,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,000,000.00 | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,374,490.76 | 9,893,850.96 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,044,000.00 | 161,802.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,330,490.76 | 9,732,048.96 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,854,297.00 | 79,752,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,396,697.00 | 73,597,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,457,600.00 | 6,155,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,184,561.64** | **62,629,632.57** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,638,510.00 | 42,358,098.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,040,510.00 | 36,959,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,598,000.00 | 5,398,198.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,546,051.64 | 20,271,534.57 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **251,337,000.24** | **-155,849,899.96** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **52,041,300.00** | **26,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **52,041,300.00** | **26,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 52,041,300.00 | 26,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 52,041,300.00 | 26,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-52,041,300.00** | **-26,500,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 199,295,700.24 | -182,349,899.96 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 73,447,544.51 | 272,743,244.75 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 272,743,244.75 | 90,393,344.79 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *//төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,145,995.32** | **536,981,496.62** | **738,095,211.54** | **1,554,222,703.48** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **279,145,995.32** | **536,981,496.62** | **738,095,211.54** | **1,554,222,703.48** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -102,300,023.47 | -102,300,023.47 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,145,995.32** | **536,981,496.62** | **635,795,188.07** | **1,451,922,680.01** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,185,366,200.00 | 1,171,196,800.00 | 14,169,400.00 | 98.80 |
| 12 | Татварын бус орлого | 1,185,366,200.00 | 1,171,196,800.00 | 14,169,400.00 | 98.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,784,000.00 | 3,600,000.00 | 5,184,000.00 | 40.98 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 3,600,000.00 | 3,600,000.00 | - | 100.00 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 5,184,000.00 | - | 5,184,000.00 | 0.00 |
| 122 | Тусламжийн орлого | 1,176,582,200.00 | 1,167,596,800.00 | 8,985,400.00 | 99.24 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,176,582,200.00 | 1,167,596,800.00 | 8,985,400.00 | 99.24 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,389,531,300.00 | 1,345,148,501.96 | 44,382,798.04 | 96.81 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,389,531,300.00 | 1,345,148,501.96 | 44,382,798.04 | 96.81 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,352,268,600.00 | 1,308,188,601.96 | 44,079,998.04 | 96.74 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,056,283,000.00 | 1,028,612,703.00 | 27,670,297.00 | 97.38 |
| 210101 | Үндсэн цалин | 611,534,100.00 | 582,051,594.00 | 29,482,506.00 | 95.18 |
| 210102 | Нэмэгдэл | 403,748,500.00 | 369,386,459.00 | 34,362,041.00 | 91.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 28,305,000.00 | (28,305,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 41,000,400.00 | 48,869,650.00 | (7,869,250.00) | 119.19 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 132,035,400.00 | 131,070,600.00 | 964,800.00 | 99.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,784,100.00 | 89,128,000.00 | 656,100.00 | 99.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,562,800.00 | 10,485,600.00 | 77,200.00 | 99.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,281,400.00 | 5,242,800.00 | 38,600.00 | 99.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,281,400.00 | 5,242,800.00 | 38,600.00 | 99.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,125,700.00 | 20,971,400.00 | 154,300.00 | 99.27 |
| 2105 | Нормативт зардал | 36,658,600.00 | 32,520,500.00 | 4,138,100.00 | 88.71 |
| 210502 | Хоол, хүнс | 36,658,600.00 | 32,520,500.00 | 4,138,100.00 | 88.71 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,007,000.00 | 16,432,048.96 | 574,951.04 | 96.62 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 17,007,000.00 | 16,432,048.96 | 574,951.04 | 96.62 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,284,600.00 | 99,552,750.00 | 10,731,850.00 | 90.27 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 103,617,200.00 | 93,397,300.00 | 10,219,900.00 | 90.14 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,667,400.00 | 6,155,450.00 | 511,950.00 | 92.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 37,262,700.00 | 36,959,900.00 | 302,800.00 | 99.19 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,262,700.00 | 36,959,900.00 | 302,800.00 | 99.19 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 37,262,700.00 | 36,959,900.00 | 302,800.00 | 99.19 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (204,165,100.00) | (173,951,701.96) | (30,213,398.04 | 85.20 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 204,165,100.00 | 173,951,701.96 | 30,213,398.04 | 85.20 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 204,165,100.00 | 173,951,701.96 | 30,213,398.04 | 85.20 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 272,743,244.75 | (272,743,244.7 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 90,393,344.79 | (90,393,344.79 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 66,188,600 | 66,188,600 | 0 | 100 |
| 12 | Татварын бус орлого | 66,188,600 | 66,188,600 | 0 | 100 |
| 122 | Тусламжийн орлого | 66,188,600 | 66,188,600 | 0 | 100 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 66,188,600 | 66,188,600 | 0 | 100 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 66,188,600 | 65,467,983.82 | 720,616.18 | 98.91 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | ,66,188600 | 65,467,983.82 | 720,616.18 | 98.91 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 66,188,600 | 65,46,7983.82 | 720,616.18 | 98.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 64,438,600 | 62,718583.82 | 1,720,016.18 | 97.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,364500 | 56,444,83.82 | 1,720,16.18 | 76.64 |
| 210302 | Түлш, халаалт | 54,374,100 | 54,374,100 | 0 | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,700,000 | 2,700,000 | 0 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,750,000 | 2,749,400 | -999,400 | 157.11 |
| 210604 | Урсгал засвар | 1,750,000 | 2,749,400 | -999,400 | 157.11 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 0 | 720,616.18 | -720,616.18 | |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0 | -720,616.18 | 720,616.18 | |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 0 | -720,616.18 | 720,616.18 | |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,480.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,483.5 мянган төгрөгийн 1 заалт зөвлөмж өгч, 3,996.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 3.1 Залруулсан алдаа байхгүй

### 3.2 Төлбөрийн акт:

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 45,000 төгрөгийн хоолны зардал болон багш, ажилтнуудад 2,059,196 төгрөгийн ээлжийн амралт, цалин давхардуулан олгосон, ёс зүйн дээд хорооны гишүүдэд 1,892,484 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2"-д Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.1-т "Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр тооцно" гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбарийн акт тогтоолоо.

### 3.3 Албан шаардлага өгөгдөөгүй

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

***Илрүүлэлт***: Сургуулийн захиралд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэмэгдэл 2,483.5 мянган төгрөгийн хөлс тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллаж, батлагдаагүй хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэмэгдэл олгохгүй байх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруу-лаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 45,000 төгрөгийн хоолны зардал давхардуулан олгосон. | 1 | 45.0 | 1 | 45.0 | | | | | | | | |
| Багш, ажилтнуудад 2,059,196 төгрөгийн ээлжийн амралт, цалин давхардуулан олгосон, | 1 | 2,059.2 | 1 | 2,059.2 | | | | | | | | |
| Ёс зүйн дээд хорооны гишүүдэд 1,892,484 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон | 1 | 1,892.5 | 1 | 1,892.5 | | | | | | | | |
| Сургуулийн захиралд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэмэгдэл хөлс урамшуулал 2,483,563 төгрөгийн нэмэгдлийг олгосон. | 1 | 2,483.5 | | | | | 1 | 2,483.5 | | | | |
| **НИЙТ** | **4** | **6,480.2** | **3** | **3,996.7** | | | **1** | **2,483.5** | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | 1 | 1 | | | 1 | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2026-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

"АЛТАН ТОСОН АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Ж.ТУНГАЛАГ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2026-02-24